



USAID
FROM THE AMERICAN PEOPLE

MONGOLIA

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ШИНЭТГЭЛ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ТӨСӨЛ



Үйл ажиллагааны Зорилго

Хувийн хэвшлийн өсөлтийг хангах таатай орчныг төлөвшүүлж, Монгол Улсын хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар хувийн хэвшил тэргүүлэх үүрэг бүхий эдийн засгийн тогтвортой өсөлтийг хурдасгаж өргөжүүлэхэд оршино.

Одоог хүртэл гүйцэтгэсэн томоохон ажлууд:

- Монгол Улсын татварын бодлогод үнэлгээ өгөх зорилгоор Засгийн газартай нягт хамтран ажиллаж, хувийн хэвшил тэргүүлэх үүрэгтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр бий болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн татварын шинэчлэлтийн төсөл боловсруулсан.
- Эдийн засгийн бодлогын гол асуудлаар олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлэгт зориулсан Бодлогын Тойм цувралыг санаачлан, одоогийн байдлаар 5 дахь дугаарыг нь гаргаад байна.
- Дотоодын хувийн хөрөнгөөр эрсдлийн капитал хөрөнгийн сан байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг хийх зорилгоор Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн, дотоодын хувийн компанитай хамтран ажиллав.
- Салбарууд, бизнесийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Өрсөлдөх чадварын сан, Бизнесийн хөгжлийн санг үүсгэн байгуулсан.
- Германы Берлин хотноо Монголын ноолуурын эцсийн бүтээгдэхүүнийг борлуулах Европ/Монголын хамтарсан төвийг байгуулахад туслалцаа үзүүлсэн.
- Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг нэгтгэснээр Аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулсан нь тус салбарын хувьд олон жилийн туршид яригдаж ирсэн асуудлыг шийдвэрлэлээ.
- Эрчим хүчний компаниудад зориулан Нягтлан Бодох Бүртгэл, Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартад нийцсэн Дансны Нэгдсэн Жагсаалт боловсруулав. Төвийн эрчим хүчний системийн эрчим хүч үйлдвэрлэгч компаниудын 2004 оны дансыг хөрвүүлэхэд туслалцаа үзүүлээ.
- Төслөөс боловсруулсан журмыг ашиглан, Эрчим Хүчний Зохицуулах Газар эрчим хүчний үнэ тарифыг тогтоох олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь Монголд ийм төрлийн анхны хэлэлцүүлэг болж, ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн томоохон алхам болсон.

Нөхцөл байдал ба шийдэл

1989 онд ЗХУ задарсанаас хойш Монгол Улс эдийн засаг, улс төрийн өргөн хүрээтэй шинэчлэлтийг хэрэгжүүлж ирсэн билээ. Төрөөс хараат эдийн засгаас зах зээлийн эдийн засагт амжилттай шилжиж байгаа нь эдүгээ Монгол Улсын ДНБ-ий 70 гаруй хувийг бүрдүүлж буй хувийн хэвшилд тусгалаа олж байна. Бэрхшээл байгаа хэдий ч сайн боловсрол эзэмшсэн, эрүүл ажиллах хүч, арвин их эрдэс баялагтай Монгол Улсын эдийн засгийн ирээдүй гэрэл гэгээтэй харагдаж байна. Хэрэгжиж буй шинэчлэлт, Орос Улсын төлөвшиж буй эдийн засаг, Хятад Улс саяхан Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэн зэрэг нэг тийш чиглэсэн хүч Монгол Улсыг дэлхийн эдийн засгийн тавцан руу хөтөлж байна. Эдийн засгийн шинэчлэлтийн явцад бодлогыг нээлттэй болгох (либералчлах) үйл явцыг хурдасгаж гүнзгийрүүлэхэд туслах, Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор ЭЗБШӨЧ төслийг хэрэгжүүлэхэд АНУ-ын ОУХА нь Кемоникс Интернэйшл компаниг сонгосон. ЭЗБШӨЧ төсөл нь дараахь чиглэлээр ажиллах замаар нэгдмэл үйл ажиллагааг бий болгоно.


- **Эдийн засаг, худалдаа, санхүү, бодлогын чиглэлээр дэмжлэг үзүүлэх:** Энэ чиглэлд дараахь үйл ажиллагаа багтана. Үүнд: (а) бодлогын үнэлгээ, дүн шинжилгээ; (б) Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор бодлогын хувилбаруудыг боловсруулах; (в) зөвшилцөлд хүрэхэд туслалцаа үзүүлэх; (г) бодлого хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон удирдлагын чиглэлээр дэмжлэг үзүүлэх.
- **Эрчим хүчний салбарын шинэчлэлтийг дэмжих:** ЭЗБШӨЧ төсөл нь хэрэглэгчдэд эрчим хүчний үйлчилгээг өрсөлдөөнтэй, үр ашигтай байдлаар хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ил тод, зах зээлийн чиг баримжаатай зохицуулалтын орчинг хөгжүүлэх ба хэрэгжүүлэх Монгол Улсын хүчин чармайлтыг дэмжих; эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч компаниудыг арилжааны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах дадлага туршлагатай болгох; гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг татах орчныг бүрдүүлэх гэх мэт дэмжлэг үзүүлдэг.
- **Бизнес ба салбар/бүлгүүдийг хөгжүүлэх:** ЭЗБШӨЧ төсөл нь экспортын чиглэлтэй, өрсөлдөх чадвартай бизнесийн байгууллагуудыг хөгжүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн гол салбаруудад аж ахуйн нэгж, компани болон хоорондоо уялдаа холбоотой ажилладаг салбар/бүлгүүдтэй хамтран ажилладаг. Тэргүүлэх чиглэлийн салбаруудад ноолуур, аялал жуулчлал, арьс, шир, савхи, мах, сүлжмэлийн үйлдвэрлэл багтаж байна.
- **Зөвшилцөл, бүх нийтийн боловсрол, үндэсний хэмжээний яриа хэлцэл:** ЭЗБШӨЧ төсөл нь эдийн засгийн шинэчлэлтийг хувийн хэвшил тэргүүлэх эдийн засгийн өсөлттэй уялдуулах замаар үндэсний хэмжээнд шийдвэр гаргагч, бизнес эрхлэгч, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагуудын удирдагч, боловсролын байгууллага болон иргэний нийгмийн төлөөлөгчдөд зөвшилцөлд хүрэх боломж олгодог төрийн байгууллагын ил тод байдал, компаний удирдлагын таатай орчныг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Хэрэгжих хугацаа:

2003 оны 9 дүгээр сар – 2008 оны 9 дүгээр сар

Хэрэгжүүлэгч байгууллагууд:

Кемоникс Интернэйшл Инк доорх компаниудтай хамтарч ажилладаг. Үүнд: Дэ Сервисэс Групп, Дексис Консалтинг Групп, Азийн Сан, Кримсон Капитал, Мэйкин Сентс



Economic Policy Reform and Competitiveness Project